



Хэвлэлийн мэдээ
2016 оны 6-р сарын 15-ний өдөр, Лхагва гараг

Холбогдох утас:
9710-9009

**Монгол дахь Америкийн Худалдааны Танхим
Агро Бизнесийн Боломжийг Судлах АНУ-ын Худалдааны Төлөөлөгчдөд
зориулсан Хүлээн Авалтыг Зохион Байгууллаа**

2016 оны 6-р сарын 14-нд Монгол дахь Америкийн Худалдааны танхим (АмЧам)-ын Агро Бизнесийн Боломжийг Судлах АНУ-ын Худалдааны Төлөөлөгчдөд зориулсан Хүлээн авалтыг АмЧамын гишүүн Жи-Мобайл ХХК ивээн тэтгэн зохион байгууллаа.

Хүлээн авалтанд Монголын хөдөө аж ахуйн салбарын тэргүүний төлөөлөгчид, Монгол дахь олон улсын санхүүгийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, АНУ-ын Элчин Сайдын Яам болон АмЧамын гишүүдээс бүрдсэн 80 гаруй зочид оролцож айлчлалын багийн төлөөлөгчидтэй бизнесийн бодит боломжуудын талаар санал солилцсон юм.

АмЧам Монголын гишүүн Жи-Мобайл ХХК Хүлээн авалтыг ивээн тэтгэж Америк-Монголын хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх болон Монгол улсын эдийн засгаа төрөлжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр орууллаа.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.